**ШУТИС, ХШУС-ийн ҮЭХорооны 2023 оны гүйцэтгэлийн тайлан**

| Огноо | Хийгдсэн ажил | Мөнгөн дүн | ТАЙЛБАР | |
|---|---|---|---|---|
| 2023.01.18 | Хамтын гэрээнд санал | | 1. Цалинг 50% хүртэл нэмэгдүүлэх. 2. Биеийн тамирын багш нарын спортын мастерын нэмэгдлийг үндсэн цалингийн 10% байхаар хөдөлмөрийн гэрээнд тусгах | 1. 2023.01.01 өдрөөс 10%, 2023.09.16 өдрөөс 15% нэмэгдүүлэв. 2. Спортын мастерийн нэмэгдлийг зохих журмын дагуу хөдөлмөрийн гэрээнд тусган шийдвэрлэнэ. 3. ШУТИС-ийн профессор багш, ажилтан докторын зэргийн урьдчилсан хамгаалалтаа амжилттай хийсэн бол 1500000 төгрөгийн тэтгэмжийг 1 удаа олгоно. |
| 2023.01.30 | Спортын тоглолтын хувцас | 4734984 | |   |
| 2023.03.03 | хандив тусламж | 50000 | Турк улсад болсон гамшигт тусламж ШУТИС-ийн ҮЭХороодууд тус бүр тавин мянган төгрөгийг хандивлав. |    |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2023.04.06 | Жагсаал цуглаан, хурал | 80000 | МБШУ-ны ҮЭХолбооны зохион байгуулсан 2022-2023 онд байгуулсан ХАМТЫН ХЭЛЭЛЦЭЭР-ийн Боловсролын салбарын ажилтнуудад хамаарах заалтууд хэрэгжихгүй байгаа тул 5000 орчим хүнтэй жагсаал зохион байгуулахад ХШУС-ийн ҮЭХорооны 8 гишүүн идэвхтэй оролцов. Дүрэмд заасны дагуу унааны мөнгө болох 10000 төгрөгийг тус бүр зарцуулав. | |
| 2023.04.10 | Тэтгэмж, тусламж | 500000 | 1. Үйлчилгээний ажилтан Х.Цэцэгбурам, Р.Дашдаваа нар тэтгэвэрт гарсан тул гишүүдэд тус бүр 50 000 төгрөгийн тэтгэмж олгов.<br>2. ХШУС-ийн багш О.Баатарзоригт, Г.Ерөөлбат нарт эмчилгээнд зориулж тус бүр 200 000 төгрөгийн тэтгэмж олгов. | |
| 2023.05.30 | Хуульд санал өгөв. | | 1. Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6, Дээд боловсролын тухай хуулийн 30.2 зүйлд санал өгөв. Төрийн өмчийн дээд боловсролын байгууллагад тогтмол болон урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх, ээлжийн амралтыг 48 хоног хэвээр хадгалах г.м саналд нийт 80 багш нэгдэн гарын үсэг зурав | |



СҮХБААТАР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

МОНГОЛЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОЛБООНД

2023.04.05 № 1/390

танай 2023.03.31 -ны № 42

Хариу мэдэгдэх тухай

Та бүхнээс ирүүлсэн Боловсрол, шинжлэх ухааны яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны Үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд 2022-2023 онд байгуулсан Хамтын хэлэлцээрийн Боловсролын салбарын ажилтнуудад хамаарах заалтууд хэрэгжихгүй байгаа тул 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр 11-14 цагийн хооронд Сүхбаатарын талбайд 5000 орчим хүнтэй жагсаал, цуглаан байгуулах хүсэлттэй танилцаж бүртгэж авлаа.

Үйл ажиллагааг зохион байгуулахдаа хот, нийтийн ээмшлийн болон иргэд, аж ахуйн нэгж байгууллагын эд хөрөнгөнд хохирол учруулахгүй байх, тудамж, замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийтийн дэг журмыг сахин биелүүлэх, хориглосон заалтуудын талаар бүхий л талын арга хэмжээг зохион байгуулагч байгууллага, хүмүүс бүрэн хариуцаж ажиллах ёстойг анхааруулъя.

Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу нийтийн хэв журамд хохирол учруулж, эмх замбараагүй байдал бий болгох, төрийн байгууллагад аливаа дарамт шахалт үзүүлэх, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцох, хуулиар хориглоогүй зорилгоор анх зохион байгуулагдсан жагсаал цуглааны явцад түүний зорилго өөрчлөгдөж дээр дурдсан агуулга шинжтэй болбол жагсаал цуглааныг цаашид үргэлжлүүлэхийг хориглоно гэдгийг анхааруулъя.

Хувийг: Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн газарт

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.АЛТАНГЭРЭЛ






УИХ-ын Дарга Г.Занданшатар

ЗГ-ын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ

БШУ-ны Сайд Л.Энх-Амгалан нарт

Хүсэлт хүргүүлэх нь

1. "БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ"-ийн өргөн мэдүүлсэн төслийн 13.3.3.-т "хөдөлмөрийн онцлогийг харгалзан *цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн* захирал, эрхлэгч болон бусад ажилтанд ажлын 15, багш, туслах багш, дотуур байрын багш, нийгмийн ажилтан, арга зүйч, сургалтын менежерт ажлын 33 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно;" гэсэн нь *өмчийн хэлбэр харгалзахгүйгээр Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургуулийн багш, ажиллагсдын* амрах хугацаа, нийгмийн баталгааг өмнө хүрсэн түвшингээс дордуулж байгаа тул "*...бүх шатны боловсролын байгууллагын багш...*" хэмээн найруулан засах эсвэл одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "Боловсролын тухай" хуулийн 43.1.2.-т заасан "...Хөдөлмөрийн онцлогийг харгалзан *багшид ажлын 33*, ... өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно..." хэмээн заасан зарчмыг хэвээр хадгалах
2. "БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬ"-ийн өргөн мэдүүлсэн төслийн 13.3.6.-т "төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Төрийн албаны тухай хуульд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох." хэмээн заасны үйлчлэх хүрээг нь тодорхой болгож, *төрийн өмчийн их сургуулиуд болон МБСБ-уудын багш, ажиллагсдыг* хамруулах
3. "ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬ"-ийн өргөн мэдүүлсэн төслийн 30.2.-т "Төрийн өмчийн дээд боловсролын байгууллагад улсын төсвөөс дэмжлэг үзүүлж болно." хэмээн заасныг тодотгож "Тогтмол болон урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж тодорхой тусгах

...рэг саналыг танд хүргүүлж байна.



ШУТИС, ХШУС -ийн багш / ажилтан

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2023.09.12 | Сургалт | | МБШУ-ны ҮЭХолбооны зохион байгуулсан"Боловсролын шинэ сэргэлтэд ҮЭ-ийн оролцоо" сургалтад ХШУС-ийн ҮЭХороодын дарга нар хамрагдав. |   |
| 2023.09.14 | Журамд санал өгөх | | ШУТИС-ийн профессор багш, ажилтны урамшууллын үнэлгээний журамд санал өгч, ШУТИС-ын ҮЭХорооны дарга нар үнэлгээний хуудас дээр ажиллаж саналаа нэгтгэв. |   |
| 2023.10.10 | Нэгдсэн арга хэмжээ | 245000 | Багш нарын баярын нэгдсэн үйл ажиллагаанд зориулав. |   |
| 2023.10.10 | Бичиг хэргийн зардал | 450000 | Принтерийн хор бичгийн цаас, бусад зардалд зарцуулав. | |
| 2023.12.21 | Тэтгэмж, тусламж | 400000 | Д.Ганзориг, М.Наранцэцэг багш нарт эмчилгээнд зориулж тус бүр 200000 төгрөгийн тэтгэмж олгов. | |
| **НИЙТ** | | **6459984** | | |

**ШУТИС, ХШУС-ийн ҮЭХорооны 2024 оны гүйцэтгэлийн тайлан**

| Огноо | Хийгдсэн ажил | Мөнгөн дүн | ТАЙЛБАР | |
|---|---|---|---|---|
| 2024.01.10 | эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг | 4746000 | ХШУС-ийн ҮЭХорооны 60 гишүүн эрүүл мэндийн үзлэгт Япон монголын нэгдсэн эмнэлэгт хамрагдав. Гишүүн тус бүрт 80000 төгрөгийн дэмжлэг үзүүлэв. | |
| 2024.01.12 | Тэтгэмж | 160000 | Х.Отгондорж, Н.Хажидсүрэн нар байнгын эмнэлэгийн хяналтад байдаг учир эмчилгээнд зориулж тус бүр 80000 төгрөгийн тэтгэмж олгов. | |
| 2024.01.24 | Сургалт: НД-ийн хуулийн шинэчилсэн найруулга, тэтгэвэр, тэтгэмжийн тухай | | ХШУС-ийн ҮЭХорооны гишүүдэд сургалт зохион байгуулав. 40 багш, ажилтан хамрагдав. |     |
| 2024.02.02 | Тусламж | 200000 | ШУТИС-ийн ажилтан Ш.Доржсүрэн, Б.Цэвэлсүрэн нарын хүсэлтийн дагуу хүүхдийн эмчилгээнд буцалтгүй тусламж 200000 төгрөг олгов. |  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2024.03.25 | Санхүүгийн тайланд аудит хийлгэв. | 440000 | ЭНИЧ-АУДИТ ХХК 2023 оны санхүүгийн тайланд аудит хийж, дүгнэлт гаргав. | |
| 2024.04.25 | Ёс зүйн хороонд гомдол гаргав. | | ШУТИС-ийн Багш ажилтны ёс зүйн зөвлөлд ЭХС-ийн Д. Үлэмжтэй холбоотой асуудлаа ГХС-тай хамтран ёс зүйн гомдол гаргасан. Олон нийтийн сүлжээнд илтэдя ялгаварлан гадуурхсан байдлаар үзэл бодлоо илэрхийлсэн. ЭХС-аас арга хэмжээ авсан тухай хариу ирсэн. Олон нийтийн сүлжээнд багш нараас уучлал гуйсан. |    |
| 2024.06.02 | Хамтын гэрээнд санал өгөв. | | Хамтын гэрээнд багш ажилтны цалинг нэмэгдүүлэх, биеийн тамирын багш, ажилтны спортын нэмэгдлийг 10% болгох, илүү цагийн кредитийн үнэлгээг нэмэгдүүлэх, 5.8 заалтад сургалтын албаны ажилтанг оруулах, эрүүл мэндийн үзлэгийн ажил олгогчийн зүгээс өгөх төлбөрийг нэмэгдүүлэх саналыг өгөв. | |
| 2024.09.15 | Хамтын гэрээний биелэлт | | ХШУС-ийн захиргаатай хамтын гэрээний биелэлтийн тайланг гаргав. 2023 оны хамтын гэрээний хүчинтэй хугацаа 2023.01.01-ээс 2024.09.15 хүртэл . | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2024.10.02 | Хэлэлцүүлэг, хурал | | МБШУ-ны ҮЭХолбооноос зохион байгуулсан " Багш нараа сонсъё" нийгмийн шинэ гэрээ, хэлэлцээр сэдэвт хэлэлцүүлэг, хуралд ШУТИС-ийг төлөөлж оролцов. |    |
| 2024.10.04 | Багш нарын баярын нэгдсэн үйл ажиллагаа | 1500000 | Багш нарын баярын нэгдсэн үйл ажиллагаанд дэлгэц, хөгжимийн үйлчилгээг Амгалан арвижин дэлгэрэх ХХК-тай гэрээ байгуулан ажиллав. |    |
| 2024.10.04 | Багш нарын баяраар ҮЭХорооны нэрэмжит шагналаар нэр бухий багш, | 140000 | Д.Ганзориг багш МБШУ-ны ҮЭвлэлийн тэргүүний ажилтанаар, Б.Батжаргал хүндэт тэмдэгээр, Ц.Батцэрэн ҮЭ-ийн жуухаар, С.Пүрэв ҮЭ-ийн хүндэт өргөмжлөл, мөнгөн шагналаар , |  |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2024.10.04 | Багш нарын баяраар нийт ҮЭХорооны гишүүдэд дурсгалын зүйл дурсгав. | 1207500 | ХШУС-ийн ҮЭХорооны нийт гишүүдэд баярын дурсгалын зүйл, нэр бүхий 8 багш ажилтныг Үйлдвэрчний Эвлэлийн 100 жилийн ойн тэмдэг, үнэ бүхий зүйлээр шагнав. |    |
| 2024.10.21 | Хамтын гэрээний сонирхлын маргаан үүсгэх хурал | | ШУТИС-ийн ҮЭХорооны бүх гишүүдийн хурлаар хамтын гэрээ хэлэлцээрийн цаг үеийн байдал, хамтын гэрээний сонирхлын маргаан үүсгэх үндэслэл, санал асуулга явагдаж, хамтын гэрээний сонирхлын маргаан үүсгэхээр гишүүд дэмжив. |     |
| 2024.11.27 | Тэтгэмж | 400000 | ҮЭХорооны гишүүн Х.Балт-Эрдэнэ, Г.Саран нарт эмчилгээнд зориулж тус бүр 200 000 төгрөгийн тэтгэмж олгов. | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2024.11.21 | Сургалт | | Тусгай хэрэгцээт суралцагчийн дээд боловсролын үйлчилгээ" сургалтыг Аутизм Монгол Анд ТББ, ХБХЭЭХолбоо, Австралийн сайн дурын мэргэжилтэн нартай хамтран зохион байгуулав. Сургалтад 42 багш, ажилтнууд оролцов. |   |
| 2024.11.24 | Хамтын гэрээний сонирхлын маргаан үүсгэж, арбитор ажиллан, арбиторын шийдвэр гаргав. | | Арбиторын шийдвэр гарав. Энэ шийдвэрийн дагуу 2024 оны 9 сарын 15 өдрөөс 30%, 2025 оны 04 сарын 1 өдрөөс 8%, 2025 оны 9 сарын 1 өдрөөс 12% тус тус нэмж багш ажилтны цалин 50% нэмэхээр хамтын гэрээг байгуулав. | <br>ХӨДӨЛМӨРИЙН АРБИТРЫН ХУРАЛДААНЫ ШИЙДВЭР<br>2024 оны 11 дүгээр сарын 21 Улаанбаатар хот<br>***Нэг. Хөдөлмөрийн арбитрын томилгооны тухай***<br>"ШУТИС-ийн захиргаа болон тус сургуулийн дэргэдэх ҮЭ-ийн хорооны хооронд 2024-2025 онд байгуулах Хамтын гэрээ"-ний цалин хөлсийг нэмэгдүүлэхтэй холбоотой шаардлагаар үүссэн хөдөлмөрийн хамтын сонирхлын маргааныг шийдвэрлүүлэхээр ШУТИС-ийн дэргэдэх ҮЭ-ийн хорооны 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 26 тоот албан бичгээр нийслэлийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хороонд ирүүлсэн хүсэлтийн дагуу "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 151 дүгээр зүйлийн 151.1 дэх хэсгийг үндэслэн Нийслэлийн Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт хорооны "Хөдөлмөрийн арбитр байгуулах тухай" 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 2 дугаар тогтоолоор Баадайн Довдонбалжир, Цагаанламын Батнасан, Бэгзсүрэнгийн Бадамсүрэн нарыг Хөдөлмөрийн арбитрчаар ажиллуулахаар томилсон юм.<br>Тус арбитрчид уг тогтоолыг 2024 оны11 дүгээр сарын 13-ны өдөр цахимаар хүлээн авч мөн сарын 14-ний өдөр бүрэн бүрэлдэхүүнээрээ анхны хурлаа хийж хуралдаан даргалагчаа сонгож арбитрийн үйл ажиллагааг эхлүүлсэн болно.<br>***Хоёр. Хөдөлмөрийн сонирхлын маргааны агуулга***<br>Маргалдагч тал болох тус сургуулийн дэргэдэх ҮЭ-ийн хорооны дарга С.Дэлгэрмаагийн гаргасан хүсэлт нь "Шинжлэх ухаан, технологийн их сургууль" болон тус сургуулийн дэргэдэх Үйлдвэрчний Эвлэлийн хорооны хооронд байгуулах 2024-2025 оны хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.3-т заасан "ШУТИС-ийн ҮЭ-ийн гишүүн профессор багш, ажилтны үндсэн цалинг 2024 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс 50.0 хувиар нэмэгдүүлнэ" гэсэн шаардлагыг захиргаа хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэнээс үүссэн хөдөлмөрийн сонирхлын маргаантай холбоотой асуудал байна.<br>Маргалдагч талууд маргаантай асуудлаа шийдвэрлүүлэхээр Сүхбаатар дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэст хандаж тус хэлтсээс 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр хөдөлмөрийн зуучлагч томилуулан зуучлалын үйл ажиллагааг эхлүүлж явуулсан байна. Гэвч зуучлагч ажиллах хугацаанд ҮЭ-ийн хорооны санал болгосон ҮЭ-ийн гишүүн профессор багш, ажилтны үндсэн цалинг 50.0 хувиар нэмэгдүүлэх асуудлаар ямар нэгэн нааштай зөвшилцөлд хүрээгүй тул<br><br>үндсэн дээр ШУТИС-ийн 2024-2025 оны хамтын гэрээндээ профессор багш, ажилтны үндсэн цалинг 2024 оны 9 дүгээр сарын 15-наас 30.0 хувиар, 2025 оны 4 дүгээр сарын 1-нээс 8.0 хувиар, мөн оны 9 дүгээр сарын 1-нээс 12.0 хувиар тус тус нэмэгдүүлэн тогтоох нь зүйтэй гэж шийдвэрлэлээ.<br>Арбитрын энэхүү шийдвэр гарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөх тул "Хөдөлмөрийн тухай хууль"-ийн 151 дүгээр зүйлийн 151.6-д заасны дагуу хөдөлмөрийн арбитрийн шийдвэрийг талууд биелүүлэх үүрэгтэйг дурдсугай.<br>ХУРАЛД ОРОЛЦСОН:<br>ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ АРБИТРЧ Б.ДОВДОНБАЛЖИР<br>ХӨДӨЛМӨРИЙН АРБИТРЧ Ц.БАТНАСАН |
| 2024.12.26 | Тэтгэмж | 50000 | ҮЭХорооны гишүүн Б.Батжаргал тэтгэвэрт гарсан тул 50 000 төгрөгийн тэтгэмж олгов. | |
| **НИЙТ** | | **8843500** | | |

**ШУТИС, ХШУС-ийн ҮЭХорооны 2025 оны гүйцэтгэлийн тайлан**

| Огноо | Хийгдсэн ажил | Мөнгөн дүн | ТАЙЛБАР | |
|---|---|---|---|---|
| 2025.01.23 | Тэтгэмж | 600000 | Б.Дуламсүрэн, Д.Илчгэрэл багш нар ШУТИС-ийн багш нарын спортын тэмцээнд бэртэл авч, эмчилгээ шаардлагатай. Б.Отгонжаргал ажил үүргээ гүйцэтгэж яваад авто машины осолд орсон тул мөн эмчилгээ, оношилгоо хийлгэх шаардлагатай болсон тул багш тус бүрт 200000 төгрөгийн тэтгэмж олгов. | |
| 2025.2.24 | Тэтгэмж | 250000 | Д.Наранцэцэг өндөр насны тэтгэвэрт гарсан тул 50000 төгрөгийн тэтгэмж олгов. Д.Ганзориг багш БНХАУ-д эмчилгээ хийлгэх шаардлагатай тул 200000 төгрөгийн тэтгэмж олгов. | |
| 2025.05.01 | Жагсаал, цуглаан | 130000 | Олон улсын хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн өдөр "Зохистой хөдөлмөр-Эрх зүйн шинэчлэл" МҮЭХолбооноос зохион байгуулсан тайван жагсаал цуглаанд 13 багш ажилтан оролцсон тул унааны мөнгө болох 10000 төгрөгийг тус бүр олгов. | <br>"ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРЧДИЙН ЭВ САНААНЫ НЭГДЛИЙН ӨДӨР"<br>ЗОХИОН БАЙГУУЛАХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР<br>**Зорилго:** Дэлхий нийтээр жил бүрийн тавдугаар сарын нэгний өдрийг "Олон улсын Хөдөлмөрчдийн эв санааны нэгдлийн өдөр" болгон тэмдэглэн ирсэн түүхтэй. Энэ өдрийг тохиолдуулан МҮЭ-ийн холбооноос "Зохистой хөдөлмөр-Эрх зүйн шинэчлэл" уриан дор хэрэгжүүлж байгаа 2025 оны ажлын төлөвлөгөөний дагуу иргэд хөдөлмөрчдийн **тайван жагсаал, цуглаан** зохион байгуулна.<br>**Оролцогчид:** Аймаг, нийслэл, салбарын ҮЭ-ийн холбоодын удирдлага, гишүүд, идэвхитэн сонгуультан, хөдөлмөрчид, МҮЭ-ийн холбооны харьяа байгууллагууд, Ерөнхий зөвлөлийн ажлын алба<br>**Зохион байгуулагдах газрууд:** Сүхбаатарын талбай<br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2025.05.03 | Витаминжуулалт | 1059240 | Витаминжуулалтын аяны хүрээнд Монос ХХК-ийн үйлдвэрлэдэг ВИТАГРИПП витаминыг ҮЭХорооны гишүүдэд олгов. |    |
| 2025.05.06 | цаг тооцох журамд санал өгөх | | Профессор багш нарын кредит цаг тооцох журамд нийт багш нараас санал авав. |   |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2025.05.28 | Сургалт | 1800000 | Стресс менежмент сургалтыг Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэнтэй хамтран 1-401А, 1-116 тоот ангид 2 баг болгон сургалтыг зохион байгуулав. Сургалтад 46 багш ажилтан хамрагдав. | <br><br><br><br> |
| 2025.10.06 | Нэгдсэн арга хэмжээ | 1650000 | Багш нарын нэгдсэн арга хэмжээ буюу багш нарын баярын арга хэмжээнд ашиглах автобусны төлбөрийг төлөв. | <br>БАГШ НАРЫН БАЯРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР<br>2025.10.04<br>8:30 Сургууль дээр цуглана<br>9:00 ШУТИС-ийн 2-р байрны үүднээс хөдөлнө.<br>11:00 Тэнгэр ресорт амралтын байранд байрлана.<br>12:00 Багш нарын баярын нээлт (Захирал үг хэлнэ.)<br>12:10 Шагнал гардуулах үйл ажиллагаа<br>12:30 Хүндэтгэлийн зоог<br>13:00 Тэнхимүүдийн мэндчилгээ (Биеийн тамир, Дотуур байр, Захиргаа, Математик, Хими, Физик)<br>14:00 Амьд хөгжимтэй "Мөнгөн харандаа" хамтлагийн тоглолт<br>16:00 Чөлөөт цаг<br>18:30 Оройн хоол<br>19:00 Диско бүжиг<br>21:00 Улаанбаатар руу автобус хөдөлнө. |
| 2025.10.06 | Шагнал | 150000 | МБШУ-ны ҮЭХолбооны хүндэт тэмдэгээр М.Амаржаргал, Г.Саран, жуухаар Н.Хажидсүрэн, Ч.Эрдэнэдалай, өргөмжлөлөөр Т.Шурэнцэцэг нар шагнуулав. | <br><br> |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2025.11.28 | Журамд санал өгөх | | ШУТИС-ийн профессор багш нарын ажлын үр дүн, ахиц дэвшлийг үнэлэх, тэнхимийн эрэмбэ тогтоох журамд БХБагтай хамтран саналыг нэгтгэж холбогдох газар руу явуулав. |  |
| 2025.12.11 | Сургалт | | МБШУҮЭХолбооны зохион байгуулсан "Манлайлал ба харилцааны ур чадвар" сургалтад хамрагдав. |  |
| 2025.12.21 | Нэгдсэн арга хэмжээ | 354000 | ХШУС-ийн багш ажилтны дунд зохион байгуулдаг спортын нэгдсэн арга хэмжээнд зарцуулав. |      |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2025.12.28 | Нэгдсэн арга хэмжээ | 1000000 | Шинэ жилийн нэгдсэн арга хэмжээнд багш, ажилтнуудын дунд урамшуулал, азтанаар ҮЭХорооны гишүүд Наранчимэг, Дуламсүрэн, Ю.Ганчимэг, Т.Энхтуяа, Т.Шүрэнцэцэг, Т.Сэлэнгэ шалгарав. |     |
| 2025.12.28 | Шагнал | 130000 | МБШУ-ны ҮЭХолбооны хүндэт тэмдэгээр Б.Бадамцэцэг, А.Сарнай, жуухаар Б.Бадам-Очир, С.Цэрэнбалжид нар шагнагдав. |   |
| 2025.12.30 | Сургалт | 2000000 | Өөрлөлтийг чиглүүлэгч төвтэй хамтран "Багт гүйцэтгэх миний үүрэг буюу багийн дотор би хэн бэ" сургалтыг 1-401А, 1-116 тоот ангиудад 2 багаар зохион байгуулав. Нийт 60 |     |
| 2025.12.30 | Тэтгэмж | 100000 | Т.Гандуламд шинэ хүүхдэд зориулсан тэтгэмж олгов. | |
| НИЙТ | | **9223240** | | |